

ТЕНДЕР ИРҮҮЛЭХИЙН ӨМНӨХ УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

№01

Улаанбаатар хот

“Эрдэнэс тавантолгой” ХК-иас зарласан ЭТТХК/20240101475 дугаартай “Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендерийн ТШЗ 10.1-д заасны дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 13 цагт zoom meeting ID 4102035897 хаягаар тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг товлосны дагуу зохион байгуулсан. Уулзалтаар тендерт оролцохыг сонирхогч 9 хуулийн этгээд мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөл 4 хүн нийт 13 хүн оролцлоо.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Тендерийн баримт бичигтэй холбоотой тайлбар болон ажлын даалгавар танилцуулах
2. Тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд тендерийн баримт бичигтэй холбогдуулан асуулт асуух
3. “ЭТТ” ХК-иас асуултад хариулж, мэдээлэл өгөх
4. Уулзалтын тэмдэглэлийн хөтөлж, цахим системд байршуулах.

СОНССОН НЬ:

“ЭТТ” ХК: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе, “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас зарласан ЭТТХК/20240101475 дугаартай Цанхийн зүүн уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн ТШЗ 10.1-д заасны дагуу тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг хийж байна.

Уг уулзалтад оролцохдоо компанийн нэр болон камерын дүрсээ өгч оролцохыг анхаарна уу. Хэрэв нэргүй, дүрсгүй уулзалтад хүсэлт илгээвэл оролцох боломжгүй гэдгийг хэлэх нь зөв байх. За юуны өмнө тус тендерт оролцохыг сонирхогчидод хандаж анхаарвал зохих зүйлийг хэлье.

1. Та бүхэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг дагаж мөрдөх дүрэм журмыг сайн судлаарай мөн цахим системтэй холбоотой санал болгож буй инженер техникийн ажилтан болон тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг төрд бүртгэлтэй байгаа мэдээллийн сангуудаас шалгана. Энэхүү мэдээллийнхээ үнэн зөв байдлыг өөрсдөө хариуцна гэдэг байдлаар оруулсан, түүнийг бас анхаараарай.
2. Мөн татварын өргүй байх, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гэх мэтчилэн тендерт оролцогчийн өөрийн асуудлууд байдаг түүнийг бас нягтлах шаардлагатай.
3. Үнийн дүн өндөр, цар хүрээ ихтэй, урт хугацааны ажлын хувьд бид авлига, ашиг сонирхолын зөрчилөөс ангид байх, бүх мэдээллээ ил тод байршуулах тал дээр онцгой анхаарч ажиллаж байна. Хэдийгээр Эрдэнэс Тавантолгой ХК дээр онцгой дэглэм тогтоосон ч гэсэн бид бүх үйл ажиллагаануудаа холбогдох хууль тогтоомжийн мөрдөж, бүх худалдан авалт тендерийн тухай хуулийн дагуу зарлагдаад явж байна. Уул уурхайн биржийн тухай хуулийн дагуу арилжаагаа мөн зохион байгуулан ажиллаж байна. Тус тендерийн өндөр үнийн дүнтэй, цар хүрээ том учраас олны анхаарлыг ихээхэн татаж байгаа байх. Тийм учраас та бүхэн бас ёс зүйтэй, зарчимтай, хууль тогтоомжоо сайн судлаад хариуцлагатай оролцоорой гэдгийг урьдчилан анхааруулах нь зүйтэй байх, мөн энэ чиглэлийн аж ахуйн нэгжүүд онцгой анхаарч байгаа байхаа гэж найдаж байна.

Ажлын даалгавраа та бүхэнд танилцуулаад холбогдох асуултанд хариулья. Ажлын даалгаварын дэлгэрэнгүйг та бүхэн тендерийн баримт бичгээс харсан байх. Үүнээс гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг та бүхэнд танилцуулья.

Энэхүү ажил сард 7,5 сая куб метр, жилд 90 сая куб метр уулын ажил гүйцэтгэнэ. Тоног төхөөрөмжийн хувьд тендерийн баримт бичиг болон ажлын даалгаварт шаардсан А. буюу Ухаж ачих, тээвэрлэх техникүүдийн мэдээллийг шалгана. Автосамосвалуудын хувьд нийлбэр даацаар нь тооцож 26,280 тонноос багагүй гэж оруулж өгсөн байгаа. Давхар тэнхлэгтэй автосамосвалууд ажиллуулахгүй. Экскаваторуудын хувьд 20-38 м3 утгуурын багтаамжтай экскаватор 9-өөс багагүй, (7-оос доошгүй нь өөрийн эзэмшлийн байх), 11-19 м3

утгуурын багтаамжтай экскаватор 7-оос багагүй байна. (5-аас доошгүй нь өөрийн эзэмшлийн байх, бүгд урвуу утгууртай байх), 5-9 м3 утгуурын багтаамжтай экскаватор 10-аас багагүй байна. (6-аас доошгүй нь өөрийн эзэмшлийн байх, бүгд урвуу утгууртай байна гэж шаардсан байгаа. Мөн В, С -д уулын туслах техник болон бусад техникийг шаардсан гэхдээ энэ нь тендерийн үнэлгээнд орохгүй. Ажил эхлэх үед бэлэн байх үүрэг хүлээнэ. Эдгээр техникүүдийн үзүүлэлтийг Хүснэгт 4-ийн дагуу бөглөж ирүүлнэ. Тендерийн баримт бичгийн маягт 3-ийг мөн бөглөж ирүүлнэ. Техникийн үзүүлэлтийг үйлдвэрлэгчийн албан ёсны танилцуулга болон вэб сайтнаас давхар шалгана. Яагаад давхар шалгах вэ гэхээр үйлдвэрлэгчийн техникийн паспортоос өөрөөр жишээлбэл утгуурын хэмжээг жижигсэх томосгох байдлаар өөрчилдөг дараа нь бодит байдалд зөрүүтэй гэх мэт маргаан үүсдэг. Ажиллах хүчний хувьд тендерт үнэлэх хүний нөөцийн мэдээллийг баримт бичгийн ТШЗ 19.1-д зааснаар үнэлнэ. Мэргэжилийн хувьд уул уурхайн чиглэлээр нилээд өргөн цар хүрээтэй шаардсан хязгаарласан зүйл байхгүй. Гүйцэтгэгчийн хувьд 3-аас доошгүй жил уул уурхайн салбарт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил, эсхүл ижил төстэй уулын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх гэж заасан.

Тендерт шалгарсан этгээдийн ажил эхлэх хугацааг Захиалагч тодорхойлохоор байгаа. Энэ нь одоо гүйцэтгэж байгаа ажлын гүйцэтгэл болон 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй уялдана. Одоо явж байгаа уулын ажил төлөвлөснөөр 10 сард дуусахаар байна. Тендерт шалгарсан этгээдээс шаардах бусад тоног төхөөрөмжийг танилцуулья.

- 2-5 м3 утгуурын багтаамжтай 2-оос доошгүй экскаваторыг уурхайд ажиллуулна.
- Уурхайд ажиллах экскаваторуудын тооноос багагүй тооны бульдозерыг ажиллуулна.
- 4 м-ээс багагүй хутганы өргөнтэй 8-аас доошгүй автогрейдеруудыг ажиллуулна.
- 20-60 тонны даацтай 6-аас доошгүй усны машинуудыг ажиллуулна.
- 2-оос багагүй утгуурт ачигчийг ажиллуулна.
- 1-ээс багагүй дугуйт түрэгчийг ажиллуулна.
- Уурхайд ажиллах экскаваторуудын тооноос 2 дахин их, түүнээс их тооны зөөврийн гэрэлт цамхагийг ажиллуулна.

Бусад техник тоног төхөөрөмжийн хувьд

- Тосолгооны машин
- Хог, хаягдлыг тээвэрлэх машин
- Автокран
- Дугуй өргөгч
- Түлшний машин
- Усны насос
- Галын машин
- Түргэн тусламжийн машинтай байна.

Дэд бүтэц, барилга, байгууламжийн хувьд

- Ариун цэврийн шаардлага хангасан кемп буюу ажилчдын сууц, амрах байр, мөн хоол хүнсний зориулалтын дагуу хадгалах агуулах
- Стандартын дагуу баригдсан ахуйн хог хаягдлын цэг
- Эрчим хүчний эх үүсвэр (нөөцийн генераторууд)
- Засварын байр, түүнийг дагалдах тоноглол, байгууламж
- Оффисын байр, сургалтын танхим
- Стандартын ашигласан тос төвлөрүүлэх байгууламж
- Хог хаягдлыг шатаах зориулалтын төхөөрөмж бүхий хоргүйжүүлэх талбай
- Бохирдсон хөрсийг төвлөрүүлэн биологийн аргаар саармагжуулах талбай

Гүйцэтгэгч нь сард 7,5-8 сая куб метр уулын ажил гүйцэтгэхээр байгаа. Үүнтэй холбоотой 0,5 хувьд бодогдох бүтээлийн бус инженерийн ажлыг гүйцэтгэхээр оруулж өгсөн.

За ажлын даалгаварыг танилцуулж дууслаа. Асуух зүйл байвал асуугаарай.

Асуулт: Төслийн ус судлал геологи нүүрсний давхрагын илэрхийлэл мэдээлэл, хүдрийн чулуулгийн хувийн жингийн мэдээлэл, хөрс хуулалт нүүрс олборлолтын харьцааг өгнө үү. Олборлолтын талбай тээврийн замын зураг, төслийн стандартыг гаргаж өгнө үү. Усан хангамж эрчим хүчний хангамж, үйлдвэрлэл, амьдрах орчны нөхцөл байдал ямар байгаа вэ? Хаягдал чулуулгийн хөрс хуулалтад тэсэлгээ хийх шаардлагатай юу? Ямар хэмжээний тэсэлгээ хийх шаардлагатай вэ? Тэсэлгээний харьцуулалт, хаягдал чулуу болон чулуулгийн тээвэрлэлтийн зайг тус тус зааж өгнө үү. Төсөл хэзээ эхлэх хугацааг тодорхойлж өгнө үү. Энэ

тендерт урьдчилгаа төлбөр байгаа эсэх? Одоо ажиллаж байгаа байгууллагын ээлжийн систем ямар байгаа вэ?

Хариулт: Эхний асуулт нь ордын геологи буюу гидрогеологитой холбоотой асуулт байна. Энэ нь компанийн нууцлалтай холбоотой учраас тодруулга өгөх боломжгүй. 2-рт чулуулгийн физик механикийн шинж чанарын бодит байдлыг асууж байх шиг байна. Үүнийг шалгарсан тохиолдолд бодит мэдээллийг өгөөд явах боломжтой. Уулзалтаар тендертэй холбоотой асуултыг асууна уу. Танин мэдэх шинж чанартай ээлжийн систем гэх мэт Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн талаар ярихгүй болохыг анхаарна уу. Олборлолтын хувьд сард 1 сая 500-аас 2 сая тонн нүүрс олборлон гэж төсөөлж байгаа. Энэхүү уулын ажилд тэсэлгээний ажил ороогүй байгаа. Эрчим хүч, усан хангамж зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. Тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохгүй сар сарын гүйцэтгэлээр төлбөр төлөгднө. Ажил эхлэх хугацааны хувьд одоо хэрэгжиж байгаа гэрээ дууссаны дараа Захиалагчаас гэрээ эхлүүлэх мэдэгдэл өгөх ба тэр хугацаанд шалгарсан оролцогч холбогдох бэлтгэл байдлаа хангаж ажиллана. Ажлын даалгаварт шаардсан стандартын дагуу ажилаа хийнэ. Компанийн дотоод асуудалд оролцохгүй.

Асуулт: Талбай дээр очиж судалгаа хийх боломжтой юу?

Хариулт: Энэ асуултад үнэлгээний хороо хуралдаж Захиалагчидаа танилцуулаад тодруулгаар хариу өгнө. Гэхдээ хугацаа богино байгаа гэдгийг ойлгож байгаа байх.

Асуулт: Тендерийн баталгааг гадаадаас хэрхэн байршуулах талаар мэдээлэл өгнө үү.

Хариулт: Тендерт төлөөлөх эрх бүхий этгээд үү түншлэлийн гишүүн үү гэдгээс хамаарна. Төлөөлөх эрх бүхий этгээд Монгол улсын хуулийн этгээд бол Монгол улсын банк эсхүл даатгалааар баталгаагаа гаргаж болно. Гадаадын этгээд бол гадаадын банкаараа баталгаагаа гаргуулаад монгол улсад “Correspondent” банкаараа дамжуулаад монгол улсын аль нэг банкаар цахим дээр байршуулах ёстой. Түншлэлтэй бол тендерийн баталгаа гүйцэтгэлийн баталгаа зэргийг төлөөлөх эрх бүхий этгээд хариуцана.

Асуулт: Техник тоног төхөөрөмж заавал tender.gov.mn -ээр дамжуулан шалгах буюу АТҮТ -ийн сайтаар шалган гэсэн байгаа. Манай компанийн машин урдаас орж ирэх учир одоогоор системд бүртгэлгүй байгаа тэрнийг өөрөөр зохицуулах боломжтой юу?

Хариулт: Тус тендерийн хувьд амжилттай болсны дараа ажил хийгдээд явна. Тэхээр Монгол улсад орж ирээгүй техникүүдийн хувьд боломжгүй. ТББ-т зааснаар АТҮТ-ийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэлийн сангаас бүх мэдээлэлээ шалгана. Мөн өөрийн эзэмшлийн хувь түрээс зэргийг шаардсан байгаа. Даацын хувьд АТҮТ дээр бүртгэгдсэн мэдээллээс шалгана. Жингийн зөрүү бас гардаг учраас систем дээр хэрхэн бүртгэгдсэнээр шалгана. Гадаадын этгээд оролцож байгаа бол ТББ-д шаардсан материалыг тухайн улсынхаа төрийн дүйцэхүйц бичиг баримтыг ирүүлнэ. Мөн шалгах нотлох баримтыг мөн ирүүлэх ёстой. Өрсөлдөх ижил тэгш боломжийг ханган гэдэг утгаараа ижилхэн дүйцэх материал ирүүлнэ. Тоног төхөөрөмжийн хувьд хийгдэх гэж байгаа ажилдаа шаардлагатай тоног төхөөрөмжийг шаардаж байгаа. АТҮТ-ийн бүртгэлийн хувьд эзэмшигч өмчлөгч гэж байгаа. Өөрөөр хэлбэл лизингтэй байгаа бол бүртгэл дээрээ энэ хуулийн этгээд нь өмчлөгч мөн гэдэг бүртгэлийг хийлгэсэн байдаг тул бүртгэлээ давхар шалгах шаардлагатай. Төрд байгаа мэдээллийн үнэн зөв байдлыг өөрсдөө бүрэн хариуцна. Бид ирүүлсэн лавлагааны дагуу үнэлгээгээ хийнэ. Инженер техникийн ажилтны хувьд мөн адилхан байна.

Асуулт: Хятадаас авч байгаа техникүүдийн хувьд харьяалагдах байгууллага лавлагаа тодорхойлолт албан бичгийг хавсаргаад явуулчихвал болох уу?

Хариулт: Хэрэв түншлэгчийн техникүүд байгаа бол танай түншлэгч тухайн мэдээлэлүүдээ хэрхэн яаж бүртгэдэг мэдээллүүдээ ирүүлнэ.

Асуулт: Цахим системээр санал болгоогүй бол хянан үзэхгүй гэж байгаа. Тэхээр нөгөө компанийн материалыг яаж хянан үзэх вэ?

Хариулт: Түншлэлээр орж байгаа тохиолдолд нөгөө компани бүртгэлтэй байх, цахимаар түншлэлтийн гэрээгээ байгуулсан байх ёстой. Холбогдох мэдээллийг тендерт оролцогч шивээд зааврын дагуу илгээх боломжтой. Бид цахимаар болон хавсралт нь цахим системд машин унших боломжтой өгөгдөл дээр нь үндэслээд аль болон тендерийн үнэлгээнд хүний оролцоогүйгээр үнэлэх болно. Өнгөрсөн жилд зохион байгуулагдсан тендерийн жишигийн дагуу энэхүү тендерийн баримт бичиг боловсруулагдсан байгаа. Бас нэг зүйлийг анхааруулахад энэхүү тендер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.11-д заасны дагуу тендерийн маягтад нэгж үнээр үнийн санал ирүүлнэ. Нийт ажлын цар хүрээг нэгж үнээр үржүүлээд ирүүлэхгүй нэгж үнээр

цахим систем болон тендерийн маягтад бөглөж ирүүлэхийг анхаарна уу. Мөн гэрээ үнийн тохируулга хийх бол нэгж үнэ дээрээ тохируулга хийгдэнэ. Урт хугацааны гэрээ хийгдэх тул үнийн тохируулга хийгдэж болзошгүй. Манай компанийн ТУЗ-аас баталсан томъёоны дагуу тохируулга хийгдэнэ.

Асуулт: Гэрээ байгуулснаас хойш хэд хоногийн дотор ажил эхлэх вэ?

Хариулт: Одоо явж байгаа гүйцэтгэгчтэйгээ уялдана. Гэрээний гүйцэтгэл 10 сард дуусахаар байгаа, хэрэв Захиалагч шаардлагатай гэж үзвэл 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцэст шахагдвал татаж оруулах ч юмуу зохицуулалт хийгдэнэ.

Асуулт: Гадаадын этгээд оролцох бол цахимд бүртгүүлэх, нийгмийн даатгалын тодорхойлолт ажиллах хүчин зэргийг хятадаас бөглөж ирүүлэх үү?

Хариулт: Гадаадын этгээд оролцох бол системдээ бүртгүүлнэ, мөн холбогдох журмын дагуу тоон гарын үсэг гэрчилгээжүүлэх байгууллагаас өөрсдөө эсвэл төлөөлөгч итгэмжлэлийнхээ дагуу тоон гарын үсгээ авна. Баримт бичгийн шаардсан материалуудыг системийн холбогдох талбаруудад шивж оруулсан байх ёстой. Мөн тухайн орныхоо ижил түвшний эрх бүхий байгууллагаас холбогдох бүх тодорхойлолтуудыг тендертээ хавсаргаж ирүүлнэ. Бид шаардлагатай бол консулаар дамжуулаад шалгах боломжтой. Тендерийн баримт бичгийн хэл Монгол хэл байна гэс заасны дагуу бүх материал монгол хэлээр баталгаат орчуулгын газраар орчуулсан байна. Тендерийн баталгаа цахимаар гаргаагүй тохиолдолд тендер нээхгүй гэдгийг анхаарна уу.

Асуулт: АТҮТ-ийн системийн мэдээлэл шинэчилэж байгаа гээд даацын мэдээлэл засах болон шинээр техник бүртгэх боломжгүй байгаа тохиолдолд яах билээ?

Хариулт: Тендерийн үнэлгээг зөвхөн АТҮТ-ийн нийт тээврийн хэрэгслийн бүртгэлийн сангаас шалгана. Энэхүү мэдээллийн санд танай мэдээлэл үнэн зөв бүртгэгдсэн эсэх дээр Захиалагчийн зүгээс ямар нэгэн хариуцлага хүлээхгүй. АТҮТ-ийн системийн шинэчлэлийг бид хариуцахгүй. Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас гаргасан ХУР системээр дамжуулан анхдагч өгөгдлийг бид шалган гэж ойлгоорой.

Асуулт: ТШЗ-16.1.2-т шаардсан шүүхийн тодорхойлолт өмнө нь цаасан хэлбэрээр аваад цахимруу скайндаж илгээдэг байсан, одоо бол цахимаар шууд илгээгдэн гэж ойлголоо. Өмнө нь 2 төрлийн тодорхойлолт шаарддаг байсан одоо бол нэг болсон байна. Оролцогчий эрхээр орохоор шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гэсэн 2 сонголт байна. Хуучин илгээдэг байснаараа 2 тодорхойлолтыг хамтад нь авах уу, эсхүл аль нэгийг нь авах уу гэдгийг тодруулж байна.

Хариулт: ТШЗ-16.1.2-т заасны дагуу Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. Цаасан скайндсан тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй, түншлэлээр оролцож байгаа бол өөр өөрийнхөө цэснээс тодорхойлолтоо аваад түншлэл болон туслан гүйцэтгэгчийн гэрээгээ байгуулаад цахимаар ирүүлнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолтыг хуулийн шинэчилсэн найруулгаар заавал байхыг болиулсан. Тус тендерт Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй.

Асуулт: ТШЗ 19.1-д шаардсан тоног төхөөрөмжийн өмчлөлийн асуудал дээр эзэмшигчийн мэдээлэл шаардсан, түрээсээр байж болно гэсэнд А,В,С -д шаардсан бүх машин техник хамаарах уу эсхүл зөвхөн А хэсгийн тоног төхөөрөмж машин механизм хамаарах уу?

Хариулт: В,С -д шаардсан техникүүдийг үнэлгээнд харгалзаж үзэхгүй, ажил эхлэхэд бэлэн байх ёстой. Уулын ажлыг гүйцэтгэх гол үндсэн техник А хэсэгт заасан техникийн хувьд эзэмшлийн мэдээллийг ТББ-д заасан хувь хэмжээгэр шалгана. Жишээлбэл автосамосвал дээр 70 дээш хувь өөрийн эзэмшил гэж шаардсан нь 100 машины 70 нь өөрийн эзэмшил 30 нь түрээсээр байж болно гэж ойлгоно. Түрээсийн гэрээгээр санал болговол түрээслэгч нь эцсийн өмчлөгч нь мөн эсэхийг мөн шалгана. Лизингээр авсан техник байгаа бол АТҮТ-ийн систем дээрх бүртгэлийн мэдээлэлээ шалгаад тендерт оролцогчийн нэрээр бүртгэгдсэн байгаа эсэхийг шалгаж нягтлах шаардлагатайг анхаарна уу. Хүний нөөцийн мэдээлэл мөн адилхан болохыг сануулж байна.

Асуулт: ТШЗ 19-ийн төгсгөлд Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно гэж байна. Тендерийн баримт бичигт заасан хүний нөөц, тоног төхөөрөмж гэх мэт маягтын дагуу материалыг бөглөж ирүүлэх юм байна, бусад албан мэдэгдэл, албан бичгүүдийг PDF хэлбэрт

хөрвүүлээд tender.gov.mn системийн холбогдох талбарт нэмэлтээр оруулах мөн зөвшөөрөгдсөн багтаамжийн шаардлагад нийцүүлээд оруулах юм байна гэж ойлголоо энэ нь зөв үү?

Хариулт: Тендерийн баримт бичигт байгаа бүх мэдээллийг тендерт оролцохыг сонирхогч этгээд ирүүлнэ. Хэрвээ аль нэг зүйл дутуу байвал татгалзах үндэслэл болно. Ирүүлэхдээ заасан арга хэлбэрээр илгээх ба машин унших боломжтой өгөгдлийг системийн холбогдох талбарт шивсэн байна. Үүнээс гадна түрээс байвал түрээсийн гэрээ гэх мэтийг хавсралт PDF файлаар тендерт ирүүлнэ. Системээс заасан хэмжээ бол тус тендерт хангалттай багтах хэмжээтэй байгаа болно.

Асуулт: Тендерийн баримт бичгийн 3-р бүлэгт заасан ажлын даалгавар гэж байгаа бид ойлгохдоо гэрээ байгуулсны дараа Гүйцэтгэгчийн хувьд биелүүлэх шаардлагатай шаардлага гэж ойлгосон. Тендерийн баримт бичгийг хүргүүлэхдээ ажлын даалгавартай холбоотой зүйлийг хүргүүлэх шаардлагагүй гэж ойлгож байгаа зөв үү?

Хариулт: Энэхүү тендерийн баримт бичиг ажлын даалгаврын зорилго нь ажил эхлэхэд бэлэн байдлаа хангаж ажиллахыг ажлын даалгаварт тодорхойлсон. Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд ямар зүйлийг үнэлгээнд харгалзан үзэж, ямар шалгуураар үнэлгээг хийх тухай мэдээллийг заасан байгаа. Мөн энэ 2 зөрсөн тохиолдолд алийг нь барихыг оруулсан байгаа. Та бүхэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, дагаж мөрдөх дүрэм журмыг сайтар судлаарай. Сангийн сайдын баталсан бүх журмууд тендерийн үнэлгээнд зарчим болж ажилдаг тул дахин сануулж хэлэхэд бүх холбогдох хууль, журмыг судлаж танилцана уу.

Асуулт: Өөрийн эзэмшил гэдгийг өөрийн өмчлөл гэж ойлгож байгаа юм байна. Тэр нь АТҮТ-ийн систем дээр өмчлөгч гэдгээр батлагдсан байхыг шаардах юм байна. Түүнтэй холбоотой манай компани жилийн өмнө худалдах, худалдан авах гэрээ хийж нилээд олон тооны тоног төхөөрөмжүүд худалдан авахаар урьдчилгаа төлбөрөө хийгээд зарим тоног төхөөрөмж хилээр ороод ирсэн гэж бодоход орж ирээгүй хилийн гадна байгаа гэрээний дагуу энэ жилдээ багтаан орж ирээд ажил эхлэхэд бэлэн байлгах тоног төхөөрөмжүүдийг өөрийн эзэмшлийн гэдэгт хамааруулах эсэх?

Хариулт: Хамааруулахгүй.

Асуулт: Ойлголоо, баярлалаа. Өөр асуулт байхгүй байна. Шаардлагатай асууж тодруулах зүйл байвал хуулийн хугацаанд дахин бичгээр гаргана.

Хариулт: За асуулт байхгүй бол уулзалтаа дуусгая. Нэмэлт тодруулах зүйл байвал хуульд заасан хугацаанд албан бичгээр цахим системийн холбогдох талбарт оруулсны дагуу Үнэлгээний хороо тодруулгын хариуг цахим системээр дамжуулан байршуулна.

Эцэст нь хэлэхэд энэ тендер нь нэгж үнээр зарлагдаж байгаа гэдгийг анхаараарай. Тендер нээх үеэр өрийн тухай асуудал үүсдэг тэрнийг мөн нягтлаарай, хууль тогтоомжоо сайн судлаж, зарчимтай ёс зүйтэй оролцохыг хүсэж байна.

Жич: Тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдтэй хийсэн тендер ирүүлэхийн өмнөх уулзалт 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 15 цаг 20 минутанд дуусав.